



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалант сумын 6 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2025/115/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Утас: 70432545 Цахим хаяг: boldbaatarkhu@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас: 70432545 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn
Аудитор: Гэрэлт Хөхийн тэнцвэр аудит ХХК-ны Д.Хишгээ
Утас: 99964238
Цахим хаяг: gerelthuhaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХОА-2025/115/НА-СТА-ТШЗ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ЖАРГАЛАНТ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 6 ДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б.БАРСБОЛД ТАНАА

2025.02.25 № 2/92
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жаргалант сумын 6 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Тайлант онд хэрэглэсэн сүү хөтөлбөрийн хүрээнд хэмнэгдсэн зардлыг төсөвт буцаан төвлөрүүлээгүй 8,606.9 мянган төгрөг
- Байгууллагын нярвын дансаар заалны орлого төвлөрүүлэн төсөвт төвлөрүүлээгүй 1,782.2 мянган төгрөгийн зөрчил илэрч, өөрийн орлогод дотоод хяналт хэрэгжүүлээгүй,
- Хоолны зардлаас бараа үйлчилгээний бусад зардал буюу цэвэрлэгээний материалын үнэ 778.8 мянган төгрөг зарцуулсан
- Хөрөнгийн ангилал зөрүүтэй бүртгэгдсэн бараа материалын шинж чанартай, ашиглах хугацаа нь дууссан 291 нэр төрлийн 375,568.9 мянган төгрөгийн тэг үлдэгдэлтэй үндсэн хөрөнгүүдтэй бүртгэлтэй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

2024 онд байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр III түвшинд, багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд 63 багш хамрагдсанаас 40 багш 1-4 дүгээр түвшинд үнэлэгдсэн бөгөөд нийт багшийн 64.7 хувь амжилттай үнэлэгдлээ.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитыг гүйцэтгэхэд материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр, тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Ховд аймгийн Боловсролын газрын даргатай 7 зорилтын хүрээнд 75 арга хэмжээ төлөвлөснөөс гүйцэтгэлийг 84.8 хувийн биелэлтэй гэж дээд шатны төсвийн захирагчаас дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

(Төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	405,454,199.2	427,321,920.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	171,208,667.7	162,023,417.6
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	171,208,667.7	162,023,417.6
3121	Төгрөг	171,208,667.7	162,023,417.6
31211	Төрийн сангийн харилцах	171,208,667.7	162,023,417.6
33	АВЛАГА	224,636.2	333,158.7
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	27,172.2	135,694.7
335	Бусад авлага	197,464.0	197,464.0
3351	Байгууллагаас авах авлага	197,464.0	197,464.0
35	БАРАА МАТЕРИАЛ	234,020,895.4	264,965,344.3
351	Түүхий эд материал	569,774.0	219,140.0
35130	Эм боох материал	569,774.0	219,140.0
354	Хангамжийн материал	233,451,121.4	264,746,204.3
35410	Бичиг хэргийн материал	2,032,250.0	2,032,250.0
35420	Аж ахуйн материал	2,741,277.0	2,741,277.0
35460	Хүнсний материал	-	7,000.0
35470	Бусад хангамжийн материал	228,677,594.4	259,965,677.3
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,430,358,128.4	2,428,880,365.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,430,358,128.4	2,428,880,365.3
392	Биет хөрөнгө	2,124,583,128.4	2,116,364,684.1
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,241,060,733.3	2,241,060,733.3
39202	Хуримтлагдсан элэгдэл	(422,235,822.0)	(528,689,902.9)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	514,121,737.9	688,848,394.9
39206	Хуримтлагдсан элэгдэл	(335,728,652.5)	(448,424,139.8)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	177,060,726.7	231,916,380.7
39208	Хуримтлагдсан элэгдэл	(127,749,701.1)	(147,575,888.2)
39217	Ном	78,054,106.0	79,229,106.0
393	Биет бус хөрөнгө	305,775,000.0	312,515,681.2
39301	Програм хангамж	857,000.0	9,844,575.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(857,000.0)	(3,103,893.8)
39303	Бусад биет бус хөрөнгө	305,775,000.0	305,775,000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,835,812,327.6	2,856,202,285.9
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	8,105,000.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	8,105,000.0
413	Өглөг	-	8,105,000.0
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	108,000.0
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	7,997,000.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,353,382,978.4	1,365,667,936.8
51	Засгийн газрын хувь оролцоо	1,353,382,978.4	1,365,667,936.8
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	305,775,000.0	305,775,000.0
51101	Өмч: - төрийн	305,775,000.0	305,775,000.0
512	Хуримтлагдсан үр дүн	259,158,682.5	271,443,640.8
51210	Өмнөх үеийн үр дүн	259,158,682.5	259,158,682.5
51220	Тайлант үеийн үр дүн	-	12,284,958.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	788,449,296.0	788,449,296.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,353,382,978.4	1,373,772,936.8

2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН (Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,517,619,322.0	4,114,461,709.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	547,105,722.0	180,967,109.0
120	Нийтлэг татварын бус орлого	547,105,722.0	180,967,109.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	547,105,722.0	180,967,109.0
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,012,400.0	22,970,800.0
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	26,974,648.0	2,315,000.0
1E+06	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	518,118,674.0	155,681,309.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,970,513,600.0	3,933,494,600.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,646,309,800.0	3,505,207,500.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,646,309,800.0	3,505,207,500.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	324,203,800.0	428,287,100.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	324,203,800.0	419,959,100.0
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	-	8,328,000.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,924,282,397.4	4,102,176,750.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,924,282,397.4	4,102,176,750.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,782,046,289.6	3,902,384,124.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,935,964,827.0	2,693,014,399.0
210101	Үндсэн цалин	1,246,605,659.0	1,659,958,405.0
210102	Нэмэгдэл	566,925,759.0	909,649,214.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	74,104,578.0	-
210104	Урамшуулал	48,328,831.0	123,406,780.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	241,911,462.9	336,542,876.0
210201	Тэтгэврийн даатгал	165,639,011.1	230,196,524.0
210202	Тэтгэмжийн даатгал	19,486,942.5	27,023,710.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,532,354.0	13,775,569.7
210204	Ажилгүйдлийн даатгал	3,744,516.3	13,086,121.0
210205	Эрүүл мэндийн даатгал	37,508,639.0	52,460,950.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	318,877,764.6	413,894,860.4
210301	Гэрэл, цахилгаан	7,896,864.6	12,434,220.4
210302	Түлш, халаалт	261,050,700.0	334,116,200.0
210303	Цэвэр, бохир ус	49,930,200.0	67,344,440.0
2104	Хангамж, бараа материалын зардал	-	45,744,044.2
210401	Бичиг хэрэг	-	80,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	45,664,044.2
2105	Нормативт зардал	85,000.0	7,677,800.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	85,000.0	7,677,800.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,745,850.0	6,000,000.0
210604	Урсгал засвар	1,745,850.0	6,000,000.0
2107	Томилолт, зочны зардал	-	1,416,000.0
210702	Дотоод албан томилолт	-	1,416,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,550,554.0	49,135,852.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,302,400.0	43,918,120.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	15,248,154.0	5,217,732.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	253,910,831.1	348,958,293.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,829,445.0	76,988,044.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,583,451.0	30,747,600.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	171,497,935.1	241,222,649.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	142,236,107.8	199,792,625.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	142,116,000.0	199,657,186.3
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	142,116,000.0	166,387,200.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	33,269,986.3
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	120,107.8	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	120,107.8	-

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	135,439.6
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	135,439.6
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	593,336,924.6	12,284,958.4

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,999,500,648.0	3,958,780,400.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	28,987,048.0	25,285,800.0
120	Нийтлэг татварын бус орлого	28,987,048.0	25,285,800.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	28,987,048.0	25,285,800.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,012,400.0	22,970,800.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	26,974,648.0	2,315,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,970,513,600.0	3,933,494,600.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,646,309,800.0	3,505,207,500.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,646,309,800.0	3,505,207,500.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	324,203,800.0	428,287,100.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	324,203,800.0	419,959,100.0
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	-	8,328,000.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,839,215,757.7	3,967,965,650.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,839,215,757.7	3,967,965,650.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,696,316,928.9	3,768,166,024.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,976,658,744.4	2,692,862,297.6
210101	Үндсэн цалин	1,292,063,233.4	1,651,695,357.0
210102	Нэмэгдэл	571,945,933.0	881,211,382.6
210104	Урамшуулал	112,649,578.0	159,955,558.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	211,343,609.2	336,695,500.0
210201	Тэтгэврийн даатгал	139,853,109.2	228,953,000.0
210202	Тэтгэмжийн даатгал	19,366,700.0	26,935,600.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,804,000.0	13,467,800.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,574,400.0	13,467,800.0
210205	Эрүүл мэндийн даатгал	35,745,400.0	53,871,300.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	318,238,692.2	413,823,660.4
210301	Гэрэл, цахилгаан	7,257,792.2	12,434,220.4
210302	Түлш, халаалт	261,050,700.0	334,116,200.0
210303	Цэвэр, бохир ус	49,930,200.0	67,273,240.0
2104	Хангамж, бараа материалын зардал	-	54,218,776.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	54,218,776.2
2105	Нормативт зардал	-	10,565,500.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	10,565,500.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,845,000.0	6,000,000.0
210604	Урсгал засвар	5,845,000.0	6,000,000.0
2107	Томилолт, зочны зардал	-	1,416,000.0
210702	Дотоод албан томилолт	-	1,416,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,305,554.0	49,428,120.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,302,400.0	43,718,120.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,003,154.0	5,710,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	152,925,329.0	203,156,170.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	127,361,829.0	172,445,270.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25,563,500.0	30,710,900.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	142,898,828.8	199,799,625.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	142,778,721.0	199,664,186.3
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	142,778,721.0	166,394,200.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	33,269,986.3
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	120,107.8	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	120,107.8	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	135,439.6
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	135,439.6

213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	160,284,890.3	(9,185,250.1)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	160,284,890.3	(9,185,250.1)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		171,208,667.7
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	171,208,667.7	162,023,417.6

2.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН (Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,788,204,349.1	788,449,296.0	259,158,682.5	2,835,812,327.6
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,788,204,349.1	788,449,296.0	259,158,682.5	2,835,812,327.6
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	12,284,958.4	12,284,958.4
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,788,204,349.1	788,449,296.0	271,443,640.8	2,848,097,285.9
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,788,204,349.1	788,449,296.0	271,443,640.8	2,848,097,285.9
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,788,204,349.1	788,449,296.0	271,443,640.8	2,848,097,285.9
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	12,284,958.4	12,284,958.4
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,788,204,349.1	788,449,296.0	283,728,599.2	2,860,382,244.3

2.5 Аудит хийсэн ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН (Төгрөгөөр)

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,286,764,000.0	3,889,152,450.1	397,611,549.9	91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,286,764,000.0	3,889,152,450.1	397,611,549.9	91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,064,815,200.0	3,689,488,263.8	375,326,936.2	91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,904,675,200.0	2,692,862,297.6	211,812,902.4	93
210101	Үндсэн цалин	2,035,429,400.0	1,651,695,357.0	383,734,043.0	81
210102	Нэмэгдэл	777,555,700.0	881,211,382.6	(103,655,682.6)	113
210104	Урамшуулал	91,690,100.0	159,955,558.0	(68,265,458.0)	174
2102	Ажил олгогчсоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	348,165,900.0	336,695,500.0	11,470,400.0	97
210201	Тэтгэврийн даатгал	236,765,100.0	228,953,000.0	7,812,100.0	97
210202	Тэтгэмжийн даатгал	27,854,700.0	26,935,600.0	919,100.0	97
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,927,300.0	13,467,800.0	459,500.0	97
210204	Ажилгүйдлийн даатгал	13,927,300.0	13,467,800.0	459,500.0	97
210205	Эрүүл мэндийн даатгал	55,691,500.0	53,871,300.0	1,820,200.0	97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	413,959,100.0	413,959,100.0	-	100
210301	Гэрэл, цахилгаан	12,569,600.0	12,569,660.0	(60.0)	100
210302	Түлш, халаалт	334,116,200.0	334,116,200.0	0.0	100
210303	Цэвэр, бохир ус	67,273,300.0	67,273,240.0	60.0	100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,000,000.0	6,000,000.0	-	100
210604	Урсгал засвар	6,000,000.0	6,000,000.0	-	100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	124,497,900.0	50,119,496.2	74,378,403.8	40

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	52,554,500.0	(9,809,280.0)	62,363,780.0	(19)
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	71,943,400.0	59,928,776.2	12,014,623.8	83
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	267,517,100.0	189,851,870.0	77,665,230.0	71
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	236,806,200.0	159,140,970.0	77,665,230.0	67
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	30,710,900.0	30,710,900.0	-	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	221,948,800.0	199,664,186.3	22,284,613.7	90
2132	Бусад урсгал шилжүүлэг	221,948,800.0	199,664,186.3	22,284,613.7	90
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	188,678,700.0	166,394,200.0	22,284,500.0	88
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	33,270,100.0	33,269,986.3	113.7	100
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,286,764,000.0	3,879,967,200.0	406,796,800.0	
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,695,460,792.7	3,460,008,100.0	235,452,692.7	
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,695,460,792.7	3,460,008,100.0	235,452,692.7	
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	420,094,539.6	419,959,100.0	135,439.6	
132001	Орон нутгийн төсвөөс	420,094,539.6	419,959,100.0	135,439.6	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	171,208,667.7		171,208,667.7	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		162,023,418	(162,023,417.6)	
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	97	103	(6.0)	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Жаргалант сумын 6 дугаар сургууль нь Монгол Улсын Үндсэн хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль болон бусад хууль, тогтоомж, Монгол Улсын Засгийн газар, Боловсрол шинжлэх ухааны яамнаас гаргасан тушаал шийдвэрийн хүрээнд хамрах тойргийн суралцагчийг бие даан сурч, амьдрахад шаардагдах суурь мэдлэг, чадварыг хөгжүүлж, ёс суртахуунтай, хариуцлагатай, ажил мэргэжлийн чиг баримжаатай иргэнийг төлөвшүүлэх зорилготой байгууллага юм.

Эрүүл биетэй, бие даан суралцах чадвартай, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлдэг, эх орныхоо түүх соёлоороо бахархдаг, зөв хандлага төлөвшилтэй суралцагчид бэлтгэх зорилготойгоор 48 бүлэгт 1426 суралцагч суралцаж 2024-2025 оны хичээлийн жилд 1-р ангид 141 суралцагч элсэн суралцсан байна.

2024 онд байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр III түвшинд, багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд 63 багш хамрагдсанаас 40 багш 1 ээс 4 дүгээр түвшинд үнэлэгдсэн бөгөөд нийт багш нарын 64.7 хувь нь амжилттай үнэлэгджээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь үйл ажиллагаандаа Боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулиудыг мөрдлөг болгохоос гадна Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалт, зарцуулалтын нийтлэг журам, бусад хууль, тогтоомж, журмуудыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 531,757.6 мянган төгрөгийн 5 зөрчил¹ илэрснээс, 144,661.8 мянган төгрөгний 3 алдааг залруулж, 10,748.1 мянган төгрөгийн төлбөрийн акт, 376,347.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

- ✦ Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн орлого, зарлага талд бусад байгууллагаас хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн 144,661.8 мянган төгрөгийг тусгасан аудитын явцад залруулга хийлгэв.

Залруулагдаагүй нийт 387,095.8 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Тайлант онд хэрэглэсэн сүү хөтөлбөрийн хүрээнд хэмнэгдсэн зардлыг төсөвт буцаан төвлөрүүлээгүй 8,606.9, үдийн хоолны зардал илүү зарлагдсан 359.0, бүгд 8,965.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 45 дугаар зүйлийн 45.2-д “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.1-д “нэгжид ногдох норм, нормативаар тооцон төсвийг нь баталсан ба гүйцэтгэл нь анх тооцсон нэгжийн тоо хэмжээнээс бага бол”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

5.1.2. Төлбөрийн акт

5.1.1 Байгууллагын нярвын дансаар заалны орлого төвлөрүүлэн төсөвт төвлөрүүлээгүй 1,782.2 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.2.1 Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус сургуулийн барилга дансанд 8 нэр төрлийн 20,012.8, машин тоног төхөөрөмж дансанд 168 нэр төрлийн 276,044.4, тавилга дансанд 115 нэр төрлийн 79,511.7 нийт 291 нэр төрлийн 375,568.9 мянган төгрөгийн тэг үлдэгдэлтэй үндсэн хөрөнгүүд байгаа нь Төсвийн тухай хуулийн 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”; 16.5.4-т “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”; /Төсвийн төвлөрүүлэн захирагчид өгөх/, Төрийн болон орон нутгийн

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

өмчийн тухай хуулийн 31.1-т "Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно." зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн ангилал зөрүүтэй бүртгэгдсэн бараа материалын шинж чанартай, ашиглах хугацаа нь дууссан хөрөнгөд байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлтийг гаргуулан ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлж ашиглах, ашиглах боломжгүй хөрөнгийг акталж устгаж эдийн засгийн хувьд үр ашигтай байхаар шийдвэрлэх

5.2.2 Төсвийн төлөвлөлт, зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хоолны зардлаас бараа үйлчилгээний бусад зардал буюу цэвэрлэгээний материалын үнэ 778.8 мянган төгрөг зарцуулсан гүйлгээ хийгдсэн нь Монгол Улсын сангийн сайдын 2023 оны 11 сарын 20-ны 211 тоот тушаалтай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Монгол Улсын сангийн сайдын 2023 оны 11 сарын 20-ны өдрийн 211 тоот тушаалаар батлагдсан Эдийн засгийн шинэчилсэн ангилал мөрдөн ажиллах.

5.2.3 Орлогын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллага нь хувь иргэдэд заал түрээслэн мөнгөн орлого бүрдүүлж байгаа ч орлогын тооцоог санхүүгийн тайланд бүртгээгүй, орлогод дотоод хяналт хэрэгжүүлээгүй, төрийн сангийн дансанд бүрэн төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Сангийн Сайдын 2012 оны 276 тоот "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам" 3.12.Эрх бүхий ажилтан хураасан орлогоо өөрийн байгууллагын бүртгэлийн дансанд ажлын 1 хоногт багтаан тушааж сар бүрийн эцэст зарагдсан тасалбарын бүртгэл болон орлого цуглуулсан баримтын (зарагдсан тасалбараас өөрт үлдэх хувь) тооцоог гаргаж, тайланг тушаана гэсэн заалтын хэрэгжилт хангагдаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн Сайдын 2012 оны 276 тоот тушаалыг баримтлан заалны орлогын тооцоог анхан шатны баримтад үндэслэн хийж, тухай бүр төрийн сангийн дансанд тушааж, заалны орлогод тавих дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа						Үүнээс:								
		Тоо			Дүн			Запуулсан			Запуулаагүй					
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн					
1	2	3	4	9	10	11	12									
6-р сургууль	Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн орлого зөрүүтэй тусгасан. Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зарлага зөрүүтэй тайлганасан Татан төвлөрүүлсэн 135.4 мянган төгрөг Төсвийн гүйцэтгэлийн тайланд тайлагнасан	1.0	72263.2	1.0	72263.2	1.0	72263.2	1.0	72263.2	1.0	72263.2	1.0	72263.2			
	Нийт дүн	3.0	144,661.8	3.0	144,661.8	3.0	144,661.8	3.0	144,661.8	3.0	144,661.8	3.0	144,661.8			

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл /Мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн				Үүнээс:									
		Тоо		Дүн		Төлбөрийн акт		Зөвлөмж							
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн						
1	2	3	4	5	6	7	8	9	10						
Жаргалант сумын 6-р сургууль	Тайлант онд хэрэгсэн сүү хөтөлбөрийн хүрээнд хэмнэгдсэн зардлыг төсөвт буцаан төвлөрүүлээгүй 8,606.9, хоолны зардал илүү зарлагдсан 359.0 Заалны орлогын төвлөрүүлээгүй Тус сургуулийн үндсэн хөрөнгө дансанд 291 нэр төрлийн 375,568.9 мянган төгрөгийн тэг үлдэгдэлтэй үндсэн хөрөнгүүд байгааг эдийн засгийн хувьд үр ашигтай байхаар шийдвэрлэх зөвлөмж өглөө. Хоолны зардлаас бараа үйлчилгээний бусад зардал буюу цэвэрлэгээний материалын үнэ 778.8 мянган төгрөг зарцуулсан Байгууллага нь хувь иргэдэд заал түрээслэн мөнгөн орлого бүрдүүлж байгаа ч орлогын тооцоог санхүүгийн тайланд бүртгээгүй, орлогод дотоод хяналт хэрэгжүүлээгүй.	1.0	8,965.9	1.0	8,965.9	1.0	1,782.2	1.0	1,782.2	1.0	375,568.9	1.0	778.7		
	Нийт дүн	5.0	387,095.8	2.0	10,748.1	3.0	376,347.6								

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Д.ХИШГЭЭ
АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЦЭГСҮРЭН
БЭЛТГЭСЭН: АУДИТОР  Д.ХИШГЭЭ